

Алтан ордны хаадад холбогдох уйгур үсгээрх зарлиг бичгүүд

Ц.Баттулга
Б.Азаяа*

Алтан ордны улсын хаадад холбогдох араб үсгээрх захидал бичгүүдийн тухай өмнө дугаарт өгүүлсэн билээ.¹ Харин энэ удаад уйгур үсгээрх зарлиг бичгийн галиг, орчуулгыг толилуулж байна. Алтан Ордны улсад холбогдох зарлиг бичгүүдээс хамгийн сонирхолтой нь уйгур үсгээр бичигдсэн зарлигууд юм. Эдгээр зарлиг бичгүүд нь Алтан ордны улсын түүх, хэл бичгийн чухал сурвалж болохын хувьд ихээхэн ач холбогдолтой. Уйгур үсгээрх зарлигуудаас хамгийн алдартай нь Токтамыш хааны 1393 оны, Тэмүр Кутлуг хааны 1397 оны зарлиг болно.

Токтамыш хааны зарлиг /1393/

Алтан ордны улсын хаан Токтамыш 1393 онд Литвийн хаан Ягайлад илгээсэн энэхүү зарлиг нь “дипломат” агуулгатайгаараа онцлогтой. Токтамыш хааны уг зарлиг Польш улсын архивт хадгалагдаж байсныг Оросын Гадаад явдлын яамны архивт шилжүүлсэн гэдэг. Сонирхолтой нь уг зарлигийг хэдэн онд ямар гэрээ хэлэлцээрээр шилжүүлсэн нь тодорхойгүй. Юутай ч, Токтамыш хааны зарлиг Оросын Гадаад явдлын яамны архивт хадгалагдаж байсныг М.Оболенский судалгааны эргэлтэнд оруулсан байна.² Хожим нь Польш, Орос улсын хэлэлцээр ёсоор уг зарлигийг Варшавын төв архивт шилжүүлжээ. Нийтдээ 25 мөрөөс бүрдэх эл зарлигийн баруун дээд буланд купи хэлбэрээр бичсэн, улаан бэх бүхий дөрвөлжин тамга буй бөгөөд энэ нь Алтан ордны улсад холбогдох захидал, харилцааны бичгүүдэд нийтлэг тохиолддог билээ.

Тэмүр Кутлуг хааны зарлиг /1397/

Алтан ордны хаан Тэмүр Кутлуг Мухаммед нэрт хүнийг алба татвараас чөлөөлж дархлан “*таркан буюудархан*” цол олгохоор 1397 онд гаргасан зарлиг юм. Энэ зарлигийг Истанбулаас А. Фон Рааб хэмээх хүн олоод түүхч Хаммерт илгээжээ. Хаммер энэ зарлигийн герман

* Монгол Улсын Их Сургууль, Гадаад хэл, Соёлын Сургууль

¹ Ц.Баттулга, Б.Азаяа, *Алтан ордны хаадад холбогдох араб үсгээрх захидал бичгүүд*, Acta Mongolica, vol.7(291), УБ., 2007, 113-122-р тал.

² М.Оболенский, *Ярлык Хана Золотой Орды Токтамыша к Польскому Каролю Ягайла* (1392-93 года), Казан, 1850

орчуулга болон араб үсгээрх эхийг 1818 онд “*Fungruben des Orients*” сэтгүүлийн VI ботид нийтлүүлжээ.³

Тэмүр Кутлуг хааны зарлиг нь хоёр өөр үсгээр бичигдсэнээрээ онцлогтой юм. Өөрөөр хэлбэл, уйгур үсгээр бичигдсэн жинхэнэ эхийн доор нь араб үсгээр хаджээ. Уйгур эхийн доор ийн хадаж бичсэн нь энэ үед арабын бичиг, хэл, соёл ихэд дэлгэрч ард нийтийн дунд уйгур бичиг мартагдаж эхэлсний нэгэн нуталгаа хэмээн үзэж болно. Гялгар, өнгөлөг цаасан дээр бичсэн, 55 мөрөөс бүрдэх уг зарлигийн эхний хоёр болон гуравдугаар мөрийг нь мөр дарж бичсэн байна.

Баруун дээд өнцөгт нь Токтамыш хааны зарлигтай адил тамга дарах зай гаргасан хэдий ч ямар нэгэн тамга даралгүй хоосон орхижээ. Тиймээс жинхэнэ эх мөн эсэх талаар маргаан ч буй. Түүнчлэн уг зарлигийн Истанбул дахь жинхэнэ эхээс хуулбарласан зөвхөн уйгур барын үсгээр бичигдсэн нэг хувилбар байдаг ажээ.⁴ Үнэндээ энэ хоёр эх огт ялгаагүй болно. Токтамыш хаан 1391 онд Бик-хажин нэрт хүнд “таркан-дархан” цол олгосон тухай араб үсгээр бичигдсэн зарлиг буй бөгөөд бид эхийг нь хараахан олж үзсэнгүй тул энд эс оруулав.

Бид уйгур үсгээрх эдгээр зарлигуудыг үгчлэн орчуулсан нь эрдэм шинжилгээний хувьд үнэ цэнэтэй байх болов уу хэмээн санасных билээ.

Уйгур үсгээрх зарлиг бичгийн латин галиг

Токтамыш хааны уйгур бичгээрх зарлиг

1. Toqtamış sözüм
2. Yağayl-a-γa
3. uluy orunγ-a oturγan ergey-in
4. aηlaηu qutlu buq-a hasan bašli ilči-
5. ler iydüк erti sen taqı kelečiq-ni
6. bizge iydiη erti burunγı yil begbolat hoja Medin (~Madin)
7. bašli bir neče oylan-lar begiř turdučaқ birdi
8. davud bašli begler edüğü atlı kiři-ni t(e)mirge aldır-
9. tin čiqarup iymişler ol til birl-e kelti erti
10. alar-niη al-a köñül bil-e til inip il qiri-γiηya
11. y(i)te kelgen-te aηlap yiyilip sančiř-may(γ)-a
12. turyan-ta ol yaman kiři-ler burun tebiregin
13. tin il tarpip ol iř taqı ol čaqlı bolγan ergey-i ol erti
14. Tηri biz-ni y(a)rliqap dūřman-lıy qilyan begbolat hoja Medin (~Madin)
15. begiř turdu-čaқ birdi davud bašli oylan-lar begler-ni
16. muηyal-(t)i emti bu yaγuni aηlaηu hasan tulu hoja bašli
17. ilčiler-ni iydüк emti taqı bols-a
18. bizge baqar iller-niη čiqiřlar-in čiqarup baryan
19. ilči-ler-ge bergil hazınege t(e)gürs-ün-ler bas-a
20. burunγı yosunča bāzeryān orηaq-lariη taqı yörüř-
21. süη-ler uluy ulus-niη turuř-iηγ-a taqı yahři-

³ A.Melek Özyetgin, *Altın Ordu, Kırım ve Kazan sahasına ait yarlık ve bitiklerin dil ve üslup incelemesi*, Ankara, 1996, s.17-18.

⁴ Ortekin Hasan, *Temir Kutluğ Yarlığı*, *Türkiyat Mecmuası*, c.III, (1926- 1933), s.207

22. sī ol bolḡay tip altun nišān-līy y(a)rl(i)ḡ
23. tut(t)uq taqayū yil tārīh yiti yüz toqsan beš
24. te rejep ay-i-niḡ sekiz yanḡta ordu tan-
25. ta erür-te bitidimiz.

Тэмүр Кутлуḡ хааны үйгүр бичгээрх зарлиḡ

1. temür qutluy söz-üm
2. oḡ qol sol
3. qol-niḡ oylan-lar-i-ḡa
4. tümen ed(i)ḡü bašlīy miḡ yüz on
5. beg-ler-i-ge ički kent-ler-i-niḡ qāzī
6. müftī-ler-i-ḡa mešāyih süfi-ler-i-ḡa
7. dīvān biḡiḡci-ler-i-ge tamyačī tart-
8. naqčī-lar-i-ḡa yortar išlenči yolavčī-
9. lar-ḡa bökevül toḡqavul-lar-ḡa yamčī
10. süsünči-ler qušči barsči-lar-ḡa
11. kemeči köprükci-ler-ge bāzār-da
12. turyan-lar-ḡa bu yarlıy-nī tuta turyan
13. muham(a)m(m)ed-niḡ öbeke ata-lar-i burun-
14. ḡi kečgen sayīn ḡan čayīdīn bir-i bir-e
15. yar-līy rāst tarḡan-līy yosun-i-ča yörüp
16. atas-i ḡājī bayram ḡoja-nī
17. biziḡ ḡan ay-a-lar-i-miz soyurqap
18. tarḡan qilyan čerge-sin aḡlata ötündü
19. erse ötülin yöp körüp muhammed
20. biziḡ soyurqal bolup tarḡan bolup
21. tursun tidimiz bu kün-din ilgerü qirīm
22. bile qirḡ yer-niḡ tömen-i-de sudaq atlıy
23. kent-niḡ jivārında burunḡi-i zamān-dīn
24. berü müteḡaddir t(a)rḡ(a)n bolyan indirči salas-i
25. bil-e mešhūr bolyan salas-i-dīn šer-i qabala
26. yosun-i-ča yer suw-l(a)r-i bil-e muh(a)m(m)ed-niḡ
27. oylan-lar-i ilk-i ḡājī muh(a)m(m)ed ve mahmūd
28. nī āzād t(a)rḡ(a)n bolsun bular-niḡ yir suw-
29. lariḡa bāy bāyča-l(a)r-i-ḡa hammām t(e)girm(e)n-
30. l(e)ri-ge t(a)sar(r)uf qıl-a turyan yer-l(e)r-i-ge
31. burun-dīn qalyan āzād-l(a)r-i-ḡa b(a)s-a sal-a-
32. l(a)r-i-ḡa s(a)b(a)nči ort(a)q-či-l(a)r-i-ḡa kim
33. kim ers-e küč oḡ-a t(e)gürmes-ün yolsuz
34. y(e)r-de n(e)m-(e)-l(e)r-i-ni tartip (almas-un)
35. almas-un-l(a)r borl-a t(a)myas-i inkinči üskü
36. bal qurti anbār mal-i indir haqq-i
37. t(a)b(a)n-līy qism(e)t qubur y(a)s(a)ḡ-i qalan müs(e)mm-ā
38. s(a)liḡ borč har(a)č alm(a)s-un-l(a)r barur kelür-i-de
39. kirür čiḡar-i-da qirīm-da kefe-de qayu-ma
40. törlüg ers-e alur-i-da s(a)t(a)r-i-da t(a)mḡ-a
41. t(a)rt(a)q alm(a)s-un t(a)rḡ(a)n-līy t(a)b(a)n-līy yol
42. haqq-i qaravul-luq tilem(e)s-ün-l(e)r t(a)v(a)r q(a)r-(a)-
43. l(a)rīn ul(a)q tutm(a)s-un qonaq tüšül tüšürm(e)s-ün-

44. l(e)r süsün 'ulüfe til(e)m(e)s-ün-l(e)r qayu-ma
 45. törlüg z(a)hm(e)t ve mu'āv-e-net ve 'avār-ī-zāt-
 46. l(a)r-dīn māsun ve m(a)hrūs bols-un-l(a)r inč
 47. turup tinčliḡ bil-e šām u sabāh evqāt-ī
 48. šerīf-l(e)r-i-de biz-ge taqī biziḡ
 49. uruy uruy-ī-miz-ya du'-ā alqīš
 50. it-e turs-un tip tuta turur-ya
 51. altun niš(ā)n-līy al t(a)mya-līy
 52. yar-līy birildi tariḡ sekiz yüz-de
 53. bars yil-ī ša'bān ayi-niḡ altinčī
 54. kün-i-de özi suyi-niḡ kenār-ī-da
 55. mūcāverān'da erür-de biḡildi.

Уйгур үсгээрх зарлиг бичгийн орчуулга

Токтамыш хааны зарлигийн орчуулга

1. Токтамыш үг ману
2. Ягайла-д
3. Өндөр дээд хаан ширээнээ заларсан болохоо
4. айлтгахаар Кутлу буха болон Хасан тэргүүтэн элч
5. нарыг илгээсэн билээ бид. Чи мөн төлөөлөгчөө
6. бидэнд ирүүлсэн билээ. Өнгөрсөн жил Бэкболат болон Мэдин(~Мадин) хожа
7. тэргүүт олон хан хөвүүд Бэкиш болон Турдучак Бирди
8. Давуд тэргүүт ноёд Эдүгү нэрт хүнийг Төмөр рүү урьдчилан
9. илгээсэн. Тэр мэдээ авчирсан.
10. Тэд далд санаатайгаар тагнуул гаргуулж улсын хилд
11. ойртож ирэх үед би үүнийг нь мэдэж цэргээ хураан дайтаж
12. эхлэх үед тэр муу хүмүүс нүүр буруулсны
13. улмаас ард түмэн дайтсан билээ. Тэр үйл тийм болсон шалтгаан нь тэр байсан юм.
14. Тэнгэр биднийг ивээж, дайсан болсон Бэк Болат болон Мэдин (~Мадин) хожа
15. Бикиш, Турдужак, Бирди Давудын удирдлага дахь хан хөвүүд, ноёдыг
16. зовоосон юм. Одоо энэ дайсныг мэдэгдэхээр Хасан болон Тулу Хожа тэргүүт
17. элч нарыг илгээлээ бид. Эдүгээ
18. бидэнд харьяат улсуудын зарцуулалт тооцоог гаргаж илгээсэн
19. элч нарт өгөгтүн! Улсын сан хөмрөгт оруулаг! Дараа нь
20. өмнөх дүрэм журам ёсоор худалдаачин болон түншүүд
21. ирж очицгоог. “Их үндэстэн гүрний сан хөмрөгт сайн нь
22. тэр болох болно” хэмээн алтан тэмдэгт зарлиг
23. бичлээ бид. Тахиа жилийн 795 он
24. –ы Долоодугаар /Рэжэп/ сарын найманы өдөр. Тан Ордод
25. байхдаа бичив бид.

Тэмүр Кутлуг хааны зарлигийн монгол орчуулга

1. Тэмүр Кутлуг. Үг ману
2. баруун хэсэг болон зүүн
3. хэсгийн хунтайж нарт
4. Түмэтийн ноён Эдүгүгийн удирдлага дахь мянгат, зуут, аравтын
5. ноёдод, дотоодын хотуудын шүүгч болон
6. сүмийн удирдагч шашны тэргүүд болон сүсэгтнүүдэд
7. зөвлөлийн бичээч нарт, гаальч хяналтын ажилтан

8. нарт, улаач болон газарч хөтөч
9. нарт цэргийн харуул болон хилийн торгон цэргүүдэд , шууданчдад хийгээд
- 10.хоол хүнс бэлдэгчидэд, шувуу, арслан тэжээгчдэд
- 11.усан цэрэг болон гүүрчдэд, зах дээр
- 12.байгсадад! Энэ зарлигийг /гартаа/ баригч (эзэмшигч)
- 13.Муххамедийн өвөг эцэг анхны
- 14./хуучин / хаан Сайин хаан / Бат хаан/-ны үеэс (эхлэн) бие биендээ
- 15.зарлигийг шууд дарханы ёсоор явуулаад
- 16.Өвөг эцэг Хажуу Байрам Хожог
- 17.бидний хаан болон ноёдын минь ач ивээлээр
- 18.тархан болгосон үеийг өгүүлэхийн тулд өргөн
- 19.барихад хүсэлтийг нь зөв гэж үзээд Мухаммед
- 20.бидний ивээлээр дархан болог
- 21.хэмээлээ бид. Энэ өдрөөс хойш Кирил
- 22.болон “Кирк ер”- ээс доош уруудан Судак хэмээх
- 23.хотын орчимд эрт цагаас
- 24.нааш үргэлжид тархан байсан тариан талбай-
25. -гаараа алдартай тосгодуудаас өгсөн баримт,
- 26.заншил ёсоор газар болоод устай нь Мухаммедын
- 27.хөвгүүд; ууган хүү Хажуу Мухаммед болон Махмуд нар
28. эрх чөлөөтэй Тархан болог. Тэдний газар ус
- 29.-ыг, цэцэрлэг талбайг, халуун ус болон тээрэм
30. -ийг хэрэглэж эзэмших эрх бүхий газруудыг
31. эртнээс үлдээсэн сул газруудыг, дараа нь тосгод
32. -ыг, тариачид болоод тариаланчдыг
- 33.хэн боловч бүү дарлагтун. Замгүй
34. газарт эд зүйлсийг нь булаан
- 35.бүү авагтун. Үзмийн тариалангийн татвар, үзэм
- 36.балт зөгий, агуулахын бараа, тариалангийн эрх
- 37.табанлык, хувь заяа, тариалангийн хууль, газрын татвар хэмээн нэрлэгдсэн
- 38.тариалангийн татвар, зээл алба гувчуур бүү аваг. Ирж буцахад
- 39.орж гарахад ч Кирилд, Кефед ч бүх
- 40.төрлийн зүйлийг авах болон зарахад гааль
- 41.хяналтын татвар бүү аваг. Дарханы табаны замын
- 42.хураамж бүү аваг. Эд юмсыг нь, мал хуйг нь
- 43.улаачийн унаа бүү болгог. (Гэрт нь хүчээр) айлчин бүү буулгаг, хонуулаг.
- 44.идэх уух зүйлс, морины тэжээл бүү нэхэг. Бүх
45. зовлонгоос, тусламж хүсэгчдээс болон татвараас
46. халдашгүйгээр хамгаалагддаг. Амар тайван байдалд
- 47.амьдарч эрүүл энх, шөнө өдрийн сайн
- 48.цагаар бидэнд болон бидний
- 49.үр саад буяныг хүсэн
- 50.залбирч байг хэмээн эзэмшүүлэхээр
- 51.алтан тэмдэгт, улаан тамгатай
- 52.зарлиг буулгав. Найман зуун оны
- 53.барс жил, наймдугаар /Шаван/ сарын зургадугаар
- 54.өдөр Өзи мөрний /Денепер/ эрэгт
- 55.Мужаверанд байхдаа бичүүллээ.

Ном зүй

Ц.Баттулга, Б.Азаяа, *Алтан ордны хаадад холбогдох араб үсгээрх захидал бичгүүд*, Acta Mongolica, vol.7(291), УБ., 2007, тал.113-122

М.Оболенский, *Ярлык Хана Золотой Орды Токтамыша к Польскому Каролю Ягайла* (1392-93 года), Казан, 1850

А.Melek Özyetgin, *Altın Ordu, Kırım ve Kazan sahasına ait yarlık ve bitiklerin dil ve üslup incelemesi*, Ankara, 1996


Ortekin Hasan, *Temir Kutluğ Yarlığı, Türkiyat Mecmuası, c.III, İstanbul, (1926-1933)*

Резюме

Были унаследованы нами некоторые источники и письма, связанные с историей Золотой Орды, которая является одной из стран наследников монгольских императоров. Из этих источников мы предлагаем к вниманию тому, кто интересуется этим вопросом, монгольские переводы писем каганов Токтамыша (1393) и Тимур Кутлуга(1397), написанные на уйгурском языке.

Хавсралт

Handwritten Mongolian script, consisting of several lines of text, likely a preface or introduction.




Handwritten Mongolian script, continuing the text from the previous section.

Handwritten Mongolian script, a single line of text.

Handwritten Mongolian script, a single line of text.

ᠲᠣᠭᠲᠠᠮᠤᠰᠢ ᠬᠠᠭᠠᠨᠢ ᠵᠢᠷᠯᠢᠭᠢ
ᠲᠣᠭᠲᠠᠮᠤᠰᠢ ᠬᠠᠭᠠᠨᠢ ᠵᠢᠷᠯᠢᠭᠢ
ᠲᠣᠭᠲᠠᠮᠤᠰᠢ ᠬᠠᠭᠠᠨᠢ ᠵᠢᠷᠯᠢᠭᠢ
ᠲᠣᠭᠲᠠᠮᠤᠰᠢ ᠬᠠᠭᠠᠨᠢ ᠵᠢᠷᠯᠢᠭᠢ
ᠲᠣᠭᠲᠠᠮᠤᠰᠢ ᠬᠠᠭᠠᠨᠢ ᠵᠢᠷᠯᠢᠭᠢ
ᠲᠣᠭᠲᠠᠮᠤᠰᠢ ᠬᠠᠭᠠᠨᠢ ᠵᠢᠷᠯᠢᠭᠢ
ᠲᠣᠭᠲᠠᠮᠤᠰᠢ ᠬᠠᠭᠠᠨᠢ ᠵᠢᠷᠯᠢᠭᠢ
ᠲᠣᠭᠲᠠᠮᠤᠰᠢ ᠬᠠᠭᠠᠨᠢ ᠵᠢᠷᠯᠢᠭᠢ
ᠲᠣᠭᠲᠠᠮᠤᠰᠢ ᠬᠠᠭᠠᠨᠢ ᠵᠢᠷᠯᠢᠭᠢ
ᠲᠣᠭᠲᠠᠮᠤᠰᠢ ᠬᠠᠭᠠᠨᠢ ᠵᠢᠷᠯᠢᠭᠢ

Токтамыш хааны зарлиг /1393/



Тэмүр Кутлуг хааны зарлиг/1397/

Handwritten Mongolian script in two columns, likely a historical document or decree. The text is dense and spans most of the page.